



# Их Эзэнээр дуудагдсан

**Ж**аред Картер, Стефен Бурнетт (Сургаал ба Гэрээ 79, 80-ыг үзнэ үү) хоёртой адил Их Эзэнээр дуудагдсан гэсэн гэрчлэл номлогчид ч гэсэн хэрэгтэй.

Коронавирусын улмаас хэдэн мянган номлогчийн дуудлагыг өөрчилсөн юм. Жишээлбэл, Көртис, Рамона Миллэр хоёр вирусын улмаас өөр номлолд томилогджээ. Тэд “Хаана үйлчлэхээс үл хамааран үйлчлэхэд бэлэн байх нь чухал гэсэн хүчтэй гэрчлэл бидэнд бий. Аврагчийн мутарт амьдралаа даатгах үед Тэрээр биднийг энэхүү ажилд тохирохоор болгодог” хэмээн гэрчилсэн.


## ЖАРЕД КАРТЕР (1801–1849)



- 1831 онд Нью-Йоркийн Колесвиллд Хайрум Смит түүнд баптисм хүртээсэн.



- 1831, 1832 онд Огайо, Пеннсилвани, Нью-Йорк, Вермонтод номлол үйлчилжээ.



- Их Эзэний таалал юу болохыг асуухаар Огайогийн Хайрам руу явав.

- Иосеф Смит Нэгдсэн Улсын зүүн мужуудад дахин номлохыг зааварласан илчлэлт хүлээн авсан (Сургаал ба Гэрээ 79-ийг үзнэ үү).



## СТЕФЕН БУРНЕТТ (1813–1885)

- 1830 онд Огайогийн Ворренвиллд Жон Мёрдок түүнд баптисм хүртээсэн.

- 17 насандаа дээд пристээр томилогджээ.

- Еден Смиттэй хамт номлох ёстой байсан боловч (Сургаал ба Гэрээ 80:2-ыг үзнэ үү) Еден өвдсөн.



- Номлолоо Едений аав Жон Смиттэй хамт эхлүүлэв.



## КӨРТИС БА РАМОНА МИЛЛЭР

- Сүмийн ахмад номлогчдын вэбсайт дээрх сонголтуудыг хараад, гол төлөв Полинез, Европ дахь найман боломжит байршлыг сонгожээ.


- Тэдэнд Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсад үйлчлэх дуудлага ирсэн.



Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс

- Тэд франц хэл сурах хэрэгтэй болсон.

- Африкт гурван сар хагас болсны дараа КОВИД-19-ийн улмаас Миллэрийнхнийг АНУ-ын Жоржиад шилжүүлэн томилжээ.



Гүрж